

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Хуулийн хэлтсийн мэргэжилтэн, Бадамдорж Баасансүрэн

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
<p>1.1. Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, сайдын болон дээд шатны байгууллагаас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих, салбарын хуулийн төсөл боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, яамны үйл ажиллагааны хүрээнд сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын гаргах шийдвэр болон яамны зүгээс бусад байгууллагатай харилцах, гэрээ байгуулахад эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих;</p>							
1	Сайдын тушаалаар батлагдсан төсөл, арга хэмжээг ТХААГ-аас тендер сонгон шалгаруулалтад шалгарсан этгээдтэй Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, этгээдтэй Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулна.	ТХААГ-аас тендер сонгон шалгаруулалтад шалгарсан этгээдтэй Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, гэрээний хугацааг сунгах арга хэмжээг зохион байгуулсан байна.	-	Зөвлөмж ирсэн тухай бүр зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан байна.	ТХААГ-аас гэрээ байгуулах нийт 5 зөвлөмж ирүүлсэн бөгөөд зөвлөмжийн дагуу бүх гэрээний төслийг боловсруулан талуудаар баталгаажуулан дараах 5 гэрээг байгуулсан. 1. "Цэцэрлэгийн барилгын холболтын зураг төсөв, 240 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, Энэтхэг-Монголын ерөнхий боловсролын сургуулийн цогцолбор/" төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>“Архитектурнэгдэл” ХХК болон үндсэн захиалагч Боловсролын яамтай 60,000,000.00 төгрөгөөр;</p> <p>2. “Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын хичээлийн байрны жишиг нэг маягийн зураг төсөв, 500 суудал /улсын хэмжээнд, коосен хөтөлбөр/” төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг “Анга транс” ХХК болон үндсэн захиалагч Боловсролын яамтай 210,000,000.00 төгрөгөөр;</p> <p>3. “Сургуулийн барилгын жишиг нэг маягийн зураг төсөв, 960 суудал /улсын хэмжээнд/” төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг “Ончтэнхлэг” ХХК ХХК болон үндсэн захиалагч Боловсролын яамтай 248,720,000.00 төгрөгөөр;</p> <p>4. “Дунд сургууль, багшийн хөгжлийн төвийн цогцолборын барилгын тухайлсан зураг төсөв, 320 суудал /Говь-Алтай, Шарга сум/” төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг “Поли лайн констракшн” ХХК болон үндсэн захиалагч Боловсролын яамтай 190,000,000.00 төгрөгөөр;</p>		
--	--	--	--	--	---	--	--

					<p>5. “Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгийн Хэрэглээний Биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/” төсөл арга хэмжээний Багц-3 “Биотехнологийн төвийн Моно-Клональ эсрэг бие үйлдвэрлэх BSL3 лаборатори байгуулах тоног төхөөрөмж” нийлүүлэх гэрээг Мед импекс интернэшнл ХХК-тай 4,950,902,000 төгрөгөөр. Түүнчлэн 2024 онд зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулагдаж он дамжин хэрэгжиж буй 7 төсөл байгаагаас 3 төслийн ажлыг дуусган холбогдох санхүүжилтүүдийг олгуулсан. Үлдсэн дөрвөн төслийн ажлыг гэрээний шатанд хэрэгжүүлж байгаа бөгөөд гэрээ сунгах болон төсөл бүрд холбогдох асуудлуудыг тухай бүр шийдвэрлүүлэхээр албан бичиг, эрх зүйн дүгнэлтүүдийг гарган удирдлагуудад танилцуулж, холбогдох газруудад хүргүүлэн гэрээний хэрэгжилтийг</p>	
--	--	--	--	--	---	--

					хангаж ажилласан.		
2	Яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ	Гүйцэтгэлийн явц, хувиар	-	Удирдлагаас хуваарилсан байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийг тухай бүр хянасан байна.	1. Боловсруулж, баталгаажуулсан тушаалууд: 1.1. "Эдийн засаг, хөгжлийн яамны албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх тухай журам"-ын төслийг хуулийн хэлтсийн бүрэлдэхүүнээр боловсруулан, нийт албан хаагчдаас нээлттэй санал авахаар байгууллагын цахим хуудсанд байршуулсан. 1.2. Эдийн засаг, хөгжлийн яамны болон Засгийн газрын холбогдох шагналд материал ирүүлсэн албан хаагчдаас шаардлага хангасан албан хаагчдыг шагнахаар Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/23 дугаар "Шагнах тухай" тушаалын төслийг боловсруулан, баталгаажуулсан. 1.3. Төрийн нарийн бичгийн даргын "үнэлгээний хороо байгуулах тухай" 2025 оны А/117 дугаар тушаалын төслийг боловсруулан, баталгаажуулж "Худалдааны хуулийн төсөл /анхдагч хууль/-ийн олон нийтийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>хэлэлцүүлэг" зохион байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулсан. 2. Эдийн засаг, хөгжлийн яамны салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны чиглэлээр хамтран ажиллах зорилгоор Монголын Хуульчдын холбоотой 2025.04.09-ны өдөр "Хамтын ажиллагааны санамж бичиг"-ийн төслийг боловсруулан, баталгаажуулсан. Хамтын ажиллагааны санамж бичигт Эдийн засаг, хөгжлийн яамыг төлөөлж Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү гарын үсэг зурсан. 3. "Гадагшаа чиглэсэн" 46 албан бичиг, "дотогшоо чиглэсэн" 26 дотоод бичигт санал, хариу хүргүүлэх тухай албан бичгийн төслийг боловсруулж, баталгаажуулсан.</p>		
3	Монгол Улсын Засгийн газар болон Эдийн засаг, хөгжлийн яамыг хариуцагчаар тодорхойлсон болон	Хувиар	-	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөл хэрэгжүүлсэн байх, тухай бүр	1. Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа "Улаан дөл" ХХК-ны нэхэмжлэлтэй маргаанд	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р	100%

<p>Нэхэмжлэл гаргах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэлээр төлөөлөх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах.</p>			<p>хууль зүйн дэмжлэг, туслалцааг үзүүлсэн байна.</p>	<p>Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03/1404 дугаар албан бичгээр олгосон итгэмжлэлээр, Эдийн засаг, хөгжлийн яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тухай бүр оролцон, ажиллаж байна. 2. Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт хянан шийдвэрлэгдэж байгаа "Хос мөнгөн зам" ХХК-д холбогдох хэрэгт Тэргүүн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 01/1371 дугаар "Нэхэмжлэл гаргах тухай" албан бичгээр Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан. Мөн тус хэрэгт Тэргүүн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 01/1372 дугаар албан бичгээр олгосон итгэмжлэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тухай бүр оролцон, ажиллаж байна. 3. Монгол Улсын дээд шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн "Пик девелопмент" ХХК-ийн нэхэмжлэлтэй Иргэний</p>	<p>сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	
---	--	--	---	--	--	--

					хэрэгт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон Засгийн газрын төлөөлөгч болон Эдийн засаг, хөгжлийн яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд алдагдал, хохирол, алдангийн тооцоо, зээлийн хүү, ханшийн зөрүүний өөрчлөлт, эдийн засгийн ач холбогдол талаас мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.		
4	Яамнаас байгуулах гэрээний төслийн хууль зүйн үндэслэлийг хянах, боловсруулах	Тухай бүр боловсруулсан, хяналт хэрэгжүүлсэн байдал, хувиар	-	Яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих гэрээний төслүүдийн хууль зүйн үндэслэлийг тухай бүр хянасан байна./100 хувь/	1. Үндэсний аудитын газраас өгсөн шаардлагын дагуу дараах гэрээний загварууд болон түүний хавсралт болох гэрээ дүгнэсэн акт, холбогдох гэрээний зүйлийн задаргаа, хуваарийн загварыг боловсруулж, удирдлагуудаар баталгаажуулсан. 1.1. Худалдах, худалдан авах гэрээний загвар болон хавсралтууд; 1.2. Үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар болон хавсралтууд; 1.3. Ажил гүйцэтгэх гэрээний загвар болон хавсралтууд; 1.4. Хөдөлмөрийн гэрээний загвар; 2. Эдийн засаг, хөгжлийн яам болон тус байгууллагын дэргэдэх	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

				<p>Ахмадын хороо нь ахмадын хорооны гишүүдэд хууль тогтоомжийн дагуу дэмжлэг, тусламж, үйлчилгээ үзүүлэх, тэдний дунд зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор "Хамтран ажиллах гэрээ"- ний төслийг боловсруулан, талуудаар баталгаажуулсан. 3. Эдийн засаг, хөгжлийн яам болон Монголын Хуульчдын Холбоо хооронд байгуулагдсан "Худалдааны хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г тендерийн жишиг баримт бичгийн форматын дагуу боловсруулан, талуудаар баталгаажуулсан. 4. Яамны зохион байгуулалтын бусад бүтцийн нэгжүүдээс боловсруулсан дараах гэрээнүүдийг хянаж, нэмэлт, өөрчлөлт оруулах саналуудыг тусгаж, боловсруулахад туслалцаа үзүүлэн ажилласан. 4.1. ЭЗХЯ/42-56 дугаар гэрээнүүд болон ЭЗХЯ/80-</p>	
--	--	--	--	--	--

141

					<p>83 дугаар бүхий "Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудтай байгуулах хөлсөөр ажиллах" гэрээнүүд; 4.2. "Монгол улсын хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөр"-ийн суралцагч, албан байгууллага, удирдах зөвлөл хоорондын гурван талт гэрээ"-ний төслийг хянаж, холбогдох дүгнэлт, саналыг хүргүүлсэн; 4.3. ЭЗХЯ/58 дугаар бүхий Удирдлагын академитай байгуулсан "Захиалгат сургалт явуулах тухай" сургалтын гэрээ; 4.4. ЭЗХЯ/17, 18, 37, 68, 70, 73 дугаар Үйлчилгээ үзүүлэх гэрээнүүд; 4.5. ЭЗХЯ/31 дугаар ажил гүйцэтгэх гэрээ; 4.6. Эдийн засаг, хөгжлийн яам болон Голомт банкны хооронд байгуулсан "Цалингийн карт болон зээлээр үйлчлэх" гэрээний төслийг хянаж, талуудаар баталгаажуулсан.</p>		
5	Салбарын хуулийн төсөл боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн	Гүйцэтгэлийн явц, оролцоо, хувиар	-	Салбарын хууль давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоо	1. Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2025 оны А/19 дүгээр тушаалаар Худалдааны тухай (Анхдагч хууль)	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар	100%

<p>уялдаа холбоог хангах ажлыг хийж гүйцэтгэх, зохион байгуулах</p>			<p>сайжирсан байна.</p>	<p>хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт гишүүнээр оролцож, хуулийн төслийг боловсруулахаар ажиллаж байна. Түүнчлэн тус хуулийн төслийг олон нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулахаар гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу холбогдох баримт, шат дамжлагын дагуу шалгаруулж, шалгарсан этгээдтэй гэрээ байгуулсан. 2. Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын "Ажлын хэсэг байгуулах тухай" 2025 оны А/18 дүгээр тушаалаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан бөгөөд тус ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, удирдлагуудаас өгсөн чиглэл, саналын дагуу хуулийн төсөл болон</p>	<p>сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	
---	--	--	-----------------------------	---	---	--

					<p>хуулийн төслийн үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулгыг боловсруулан бүх сайд нараас санал авсан. Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулагдах хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний тайлан, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ болон төслийн зардлын тооцооны судалгааны тайлангуудыг боловсруулан ажиллаж байна. 3. Улаанбаатар хотын танхимаас Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах гадаадын хөрөнгө оруулалтын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиудад оруулах саналыг хариуг боловсруулан удирдлагуудад хүргүүлсэн.</p>		
6	Салбарын хууль тогтоомж болон сурталчилах үйл	Хувиар	-	Салбарын хууль тогтоомж болон сурталчилах үйл	Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р	100%

<p>ажиллагааны хэрэгжилтийг нэгтгэх</p>			<p>ажиллагааны хэрэгжилтийг яамны нэгж бүрээс авч нэгтгэсэн байна.</p>	<p>эрхлэх асуудлын хүрээнд холбогдох, Засгийн газарт эрх олгосон 46 хуулийн заалтын дагуу батлагдах хэм хэмжээ тогтоосон актуудын хэрэгжилтийг яамны нэгж газруудаас авч, нэгтгэхэд сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй 10, хуулийн хэрэгжилтийг хангаж Засгийн газрын тогтоол гарсан 27, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулахаар холбогдох хэм хэмжээ тогтоосон актыг хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтыг судалж буй 6, журмын төслийг боловсруулан санал авч буй 1, Засгийн газар Улсын их хуралд өргөн барьж батлуулсан 2 зохицуулалт байсан. Иймд Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 191 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн баталсан “Захиргааны хэм хэмжээний актыг цэгцлэн хуулийн төсөл боловсруулах ажлын удирдамж”-ийн хүрээнд дээрх 46 хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дараах 10 журмыг бүхэлд нь хүчингүй болгож,</p>	<p>сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	
---	--	--	--	---	---	--

				<p>холбогдох зохицуулалтыг хуульд тусгах ажлыг зохион байгуулах саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн. 1. Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам; 2. Зөвшөөрлийн зөвлөлийн ажиллах журам; 3. Зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч нь тодорхойгүй бүтээлийг ашигласны төлбөрийг зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчид нөхөн олгох журам; 4. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам; 5. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам; 6. Оюуны өмчийн үндэсний зөвлөлийн ажиллах журам; 7. Маргаан шийдвэрлэх зөвлөлийн ажиллах журам; 8. Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлох, санхүүжүүлэх журам; 9. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох журам; 10.</p>	
--	--	--	--	---	--

					Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, эзэмшүүлэх журам Түүнчлэн Хуулийн хэлтсийн 2025 оны эхний улирлын хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийн тайланг гаргаж, хуулийн хугацаанд хүргүүлсэн.		
7	Цаг үеийн шинжтэй шуурхай үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлэх	Хэрэгжилтийн явц, хувиар	-	Хуулийн хугацаанд шуурхай биелүүлсэн байх/ 100 хувь/	1. Японы Олон Улсын хамтын ажиллагааны агентлаг (ЖАЙКА)-аас зохион байгуулсан " Enhancement of Startup Ecosystem in Metropolitan Area" сэдэвт сургалтад бүх газар нэгжүүдээс санал авч Эдийн засаг, хөгжлийн яамны нэг албан хаагчийн холбогдох материалыг бүрдүүлэн хамруулсан. 2. Удирдлагын Академийн сургалт, судалгааны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан сургалтуудад суралцуулах албан хаагчдыг тодорхойлохоор ажиллаж буйтай холбогдуулан тус байгууллагаас Эдийн засаг, хөгжлийн яамнаас хамрагдсан төгсөгчдийн мэдээллийг авч яамны	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>квотод сурсан боловч төгсөөгүй сурагчдад холбогдох мэдээллийг хүргүүлж, сурч төгсөхийг мэдэгдсэн. 3. Архивын Ерөнхий газрын 2025 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан мэргэжлийн болон мэргэшүүлэх чадамжийн сургалтуудад яамны архивын эрхлэгч болон бичиг хэргийн ажилтнуудыг хамруулсан. 4. Удирдлагын Академийн 2025 оны сургалт, судалгааны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх сургалт, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтуудад яамны 15 албан хаагчийн холбогдох материалыг хүргүүлж, хамруулсан. 5. Удирдлагын академийн гадаад хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан "Төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ" танхимын болон цахим, гадаад аялал-сургалт хосолсон богино</p>	
--	--	--	--	--	--	--

					хугацааны цогц сургалтад яамны гурван албан хаагчийн материалыг бүрдүүлэн нэр дэвшүүлэн, хүргүүлсэн.		
<p>3.1. Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, сайдын болон дээд шатны байгууллагаас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих, салбарын хуулийн төсөл боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, яамны үйл ажиллагааны хүрээнд сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын гаргах шийдвэр болон яамны зүгээс бусад байгууллагатай харилцах, гэрээ байгуулахад эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих;</p>							
8	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Тогтоосон хугацаанд үнэн зөв боловсруулах	2024 онд ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь боловсруулсан болно.	2025 онд ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас жилээр хугацаанд нь боловсруулсан байна.	Төрийн албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж батлуулсан/2025.01.15 болон 2025.03.25/. Тус батлуулсан төлөвлөгөөний биелэлтийг хангаж, гүйцэтгэлийг тухай бүр тайлагнан ажиллаж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
9	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай	Хууль тогтоомжид заасан нийтлэг үүргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах.	2024 онд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл,	Хууль тогтоомжид заасан нийтлэг үүргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан байна.	1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу 2025.02.07, 2025.04.03-ны	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар	100%

14/5

<p>хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх</p>		<p>гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан.</p>	<p>өдрүүдэд ХАСХОМ, 2025.02.07-ны өдөр ХАСУМ тус тус мэдүүлэн, баталгаажуулсан. 2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасны дагуу 2023 болон 2024 оны тус хэлтэст хамаарах гэрээний архивыг хэлтсийн бүрэлдэхүүнээр хийсэн. 3. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасанчлан өөрт цохогдож ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж 2025 оны эхний хагас жилийн байдлаар Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг бүрэн</p>	<p>сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>
---	--	--	--	--

				хэрэгжүүлж ажилласан.		
--	--	--	--	-----------------------	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Өөрийн хариуцсан ажлын хүрээнд мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн байх	Сургалтад хамрагдсан байх	-	Сургалтад хамрагдсан байх	1. Удирдлагын академийн "Ухаалаг төхөөрөмж" сэдэвт цахим сургалтад сууж орчин үеийн ухаалаг төхөөрөмжүүдийг хэрхэн үр дүнтэй ашиглах талаар суралцсан. 2. Удирдлагын академийн "Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь" сэдэвт цахим сургалтад сууж нийгмийн эгэх хариуцлагын үндсэн ойлголт болон сайн туршлагуудын талаар судалсан. 3. Удирдлагын академийн "ERP систем" сэдэвт цахим сургалтад сууж тус системийн бүрэлдэхүүн, ашиглалтын давуу талын талаар судалсан. 4. АНУ-ын Худалдааны яамны Эрхзүйн арилжааны хөтөлбөртэй хамтран дэд бүтцийн төслийн гэрээний эрхзүйн чиглэлээр чадавх сайжруулах зорилгоор яамнуудын хуульчдад сургалт хамтран зохион байгуулахаар ажилласан бөгөөд тус сургалтын хүрээн дэх түншлэлийн хүрээн дэх онлайн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

146

				яамнаас 2025.03.13-ны өдөр зохион байгуулсан "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн форум"-д оролцсон.		
--	--	--	--	--	--	--

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ТЗУГ-ын Хуулийн хэлтсийн дарга Д.Ариунбилэг /...../

Огноо: 2025.06.25

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хуулийн хэлтсийн мэргэжилтэн, Бадамдорж Баасансүрэн /...../

Огноо: 2025.05.25

